

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2011-12-23/**

Ажлын хэсгийн хуралдаан 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр (Баасан гариг)-ийн 11.00 цагт Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн байрны 5 дугаар давхарын хурлын танхимд болов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, ажлын хэсгийн гишүүд Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга С.Мягмардаш, Авилгатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Дуламсүрэн, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Нүүрс ассоциацийн захирал Л.Даваацэдэв, Нээлттэй нийгэм форумын уул уурхайн менежер Н.Дорждарь, Инфорум төвийн тэргүүн А. Батпүрэв, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Монголын байгаль орчны ТББ-ын холбооны иргэний зөвлөлийн гишүүн Б.Батболд, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумьяа нар оролцов. Хуралдаанд ажлын хэсгийн гишүүдийг төлөөлж Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дэлгэрбаяр, Газрын тосны газрын хөрөнгө оруулалтын хяналтын тасгийн дарга Э.Оюун, Үндэсний татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын эрдэс баялгийн татварын хэлтсийн ахлах байцаагч Т.Цэцэгням, байцаагч Энхтуяа, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Ц.Цэгц, мэргэжилтэн С.Мөнхсайхан, Бороо гоулд ХХК-ийн мэргэжилтэн Б.Ганхүлэг, Монголын ажил олгогч эздийн холбооны мэргэжилтэн Д.Нанжидсамбуу нар оролцов. Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон хуралдаанд оролцогчдын ирц 70 хувьтай байгааг танилцуулав.

Хуралдаанд ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн гишүүн, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн, ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, Улаанбаатар Аудит корпорацийн ерөнхий захирал Б.Осогарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, Мэндбаяр, аудитор Отгонхүү, Болортуяа, Европын СБХБ-ны санхүүжилтээр төсөл хэрэгжүүлж буй Адам Смит байгууллагын орон нутгийн зөвлөх Ч.Энхзаяа Далайван аудит компанийн ерөнхий захирал Б.Жигдэн, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Харилцаа, мэдээллийн мэргэжилтэн С.Батбаяр нар урилгаар оролцлоо.

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор нээж хэлэхдээ “Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаанаар гурван асуудал хэлэлцэж, дөрөвдөх асуудлыг танилцуулж санал авна. **Нэгдүгээрт:** Монгол Улсын ОУИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан тайлан, дүгнэлтүүд, **хоёрдугаарт:** Тайлан гаргах эрхзүйн үндэс болон практик, **гуравдугаарт:** Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2011 оны аудитын нэгтгэл тайлан гаргах байгууллагын сонгон шалгаруулалтын удирдамж, Үнэлгээний хорооны тухай зэрэг асуудлуудыг авч хэлэлцэнэ. Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох, авах арга хэмжээний тухай танилцуулгыг сонсоно” гэв. Дараа нь хурлын дотоод журмын төслийг танилцуулж, хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмын талаар гишүүдийн зөвшөөрлийг авснаар хуралдааныг эхлүүлэв.

**I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан тайлан, дүгнэлтүүд**

Танилцуулгын эхэнд Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргаав “Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бид ОҮИТБС-ын 2010 оны тайланг хийж 12 дугаар сарын 16-наар тасалбар болгосон урьдчилсан нэгтгэлийн тайланг танилцуулах гэж байна. Аудитын тайлангийн урьдчилсан дүгнэлтийн талаар ахлах аудитор Н.Эрдэнэцог та бүхэнд танилцуулга хийнэ” гэв.

Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ахлах аудитор Н.Эрдэнэцог Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан тайлан, дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулав (танилцуулгыг хавсаргав).

**Б.Долгор:** За баярлалаа. Асуулт тавих хүн байна уу?

**Н.Дорждарь:** Хоёр асуулт байна. Эрдэнэт УБҮ-ийн аж ахуйн нэгжийн татвар 2010 онд хэдэн төгрөг төлсөн бэ гэдгийг аль хуудаснаас харж болох вэ? Компани тус бүрээр нь харж болох уу?

**Н.Эрдэнэцог:** Урьдчилсан тайлан тул компани болгоноор гаргасан хавсралтыг хавсаргаагүй байгаа. Эцсийн тайлан дээр хавсаргаж гаргана.

**Н.Дорждарь:** Зөвлөмж дээр хураамж, үйлчилгээний хөлс маш бага дүнтэй байгаа учраас энийг хасах саналтай байгаа юм байна. Mash бага гээд байгаагийн тоог хэлэх бололцоо байна уу? Ямар учраас маш бага гэсэн юм бэ?

**Н.Эрдэнэцог:** Компани нь төрийн байгууллагад төлсөн бүх хураамж, үйлчилгээний хөлсийг гаргаад өгдөг. Жишээ нь: замын хураамж гээд 22-ын товчоогоор гаражад 500 төгрөг хураалгах гэх мэт тэр болгоныг нягтлан бодох бүртгэлдээ бүртгэсэн байна. Гэтэл Засгийн газар талаасаа түүнийг хүлээж авсан байх ёстой байдаг. 22-ын товчоонд тэдэн сарын тэдэнд тэр 500 төгрөг төлсөн байна гэсэн тайлагнал байдаггүй. Иймэрхүү маш олон хураамжууд байдаг. 21 аймгийн 129 суманд тараагаад төлсөн байдаг, харин Засгийн газар талаасаа тайлан байдаггүй. Үүнээс болоод зөрүү үүсээд байдаг. Тэгээд энэ зөрүү шийдвэрлэгдэхгүй үлддэг. 500, 1000 төгрөгийн хураамж байдаг. Түүний төлөө явахад үнэхээр барагдахгүй их, ач холбогдолгүй ажил болоод байгаа юм. Гэхдээ том дүнтэй хураамж байдаг л даа. Тийм учраас материаллаг байдлыг нь тогтоовол хийж болох ажил.

**А.Батпүрэв:** Нөхөн сэргээлттэй холбоотой асуудал дээр тайланд хамрагдсан компаниуд төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлын техникийн нөхөн сэргээлтийг 96 хувьтай, биологийнх 81 хувьтай хийсэн байна гэжээ. Энэ тоо ямар үндэслэлээр гарч ирж байгаа вэ? Хир баталгаажсан тоонууд вэ?

**Н.Эрдэнэцог:** Компаниуд уулын ажлын төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн мэдээ гэх мэт тайланг Ашигт малтмалын газарт явуулдаг. Энэ тайлангийнхаа хуулбарыг

бидэнд ирүүлдэг. Яг эндээс авсан тоо баримт юм. Харин Ашигт малтмалын газраас хир хяналт тавьдагийг бид сайн мэдэхгүй байгаа. Мөн өөрсдийгөө ийм их ажил хийчлээ гэх, бас мэдээ тайлангийн чанартай холбоотой зүйл бий.

**А.Батпүрэв:** Зөвлөмж дээр сайн оролцож байгаа компаниудыг сайшааж, мууг нь донгodoх хэрэгтэй гэсэн байна. Эдгээр компаниудыг Саначлагад оролцсон байдлаар нь нэр хүндэд нь халдах хууль эрх зүйн боломж бий болов уу?

**Н.Эрдэнэцог:** Хууль эрхзүйн зүйл байхгүй болов уу. Гол нь олон нийтэд таниулах хэрэгтэй. ОҮИТБС гэж байгааг болон яагаад тайлангуудыг нэгтгээд байгааг сайтар танилцуулах хэрэгтэй.

**Б.Осогарав:** Хуулийн төсөл буцаагдаад, одоо шинээр бэлтгэж байгаа гэсэн. Сурталчилгааны ажил их хэрэгтэй байна. Саяхан 11 дүгээр сард Үндэсний зөвлөлөөр 2009 он тайланг хэлэлцэж, зарим нэг компанийг сайн, муу гээд дурдсан шүү дээ. Энэ хуралдааны дүнгийн талаар хэвлэлийн бага хурал хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Түүний маргаашнаас эхлээд компаниуд өөрсдөө утасдаад тайлангийн талаар анхаарал тавьж эхлэсэн шүү. Тийм учраас сурталчилгаа маш чухал болохыг харуулсан. Ялангуяа саяны Үндэсний зөвлөлийн хурлын сурталчилгааг бүх телевизээр хийсэн нь үр дүнтэй байсан.

**Н.Алгаа:** Хууль эрх зүйн орчин гээд юм шаардаад байх. Энэ чинь хaa хаанаа хүндрэлтэй юм. Хууль гарахын хувьд Засгийн газар ямар бэрхшээлтэй зам туулж байгаа билээ. Энэ талаар Ажлын алба, Үндэсний зөвлөлийн болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар, Засгийн газрынхан байнга ажиллаж нэг удаа оруулаад буцсан ба одоо дахиад оруулахаар бэлтгэлээ хийгээд явж байна. Үүн дээр Засгийн газар, компани, иргэний нийгэм 3 тал хууль эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж байна. Үүнээс өмнө юуны түрүүнд сурталчилгааны ажил нэлзэн сайн хийх хэрэгтэй байна.

**Б.Долгор:** Бизнесийн нэр хүндэд нь халдаж байгаа л даа ер нь. Сайн нь ийм байна, муу нь тийм байна гээд. Торгууль хүлээлгэж байгаа. 2009 оны нэгтгэлээр бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 41 компанид 31 сая төгрөгийн торгуулийн хариуцлага хүлээлгэсэн байгаа.

**Н.Нанжидсамбуу:** ОҮИТБС-ын хүрээнд олон улсын түвшинд бизнесийн нэр хүндэд халдах, хууль тогтоомжын торгууль ногдуулах гэх мэт жишиг нь ямар байдаг бол?

**Б.Долгор:** Ерөнхийдөө бид энэ дээр тусгайлсан хууль гаргах гээд ажиллаж байгаа. Хуулийн төсөл санаачилсан. Гэвч энэ нь сайн дэмжлэг авч чадаагүй. Одоо Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас төсөл хэрэгжүүлж хуулийн төсөл боловсруулаад явж байна. Энэ төслийн багийн танилцуулга нь энд байна, өнөөдөр Ажлын хэсэг танилцана. Одоо бол мэдээ тайлан гаргахтай холбогдуулан хариуцлага тооцоод явж байгаа.

**С.Мягмардаш:** Зөрүү өнөөдрийн байдлаар хэд болчихов? Цаашид бууруулах боломж байна уу?

**Б.Осоргаав:** 12 дугаар сарын 16-ны байдлаар тасалбар болгоод 426.5 сая төгрөгийн үлдэгдэл зөрүү байгаа. Багануур ХХК дээр дарга, санхүүгийн ажилтан нь солигдоод тайлан гаргах хүн олдохгүй их хугацаа алдсан. Мөн Говьгео ХХК-ийн удирдлага нь гадаад, дотоод яваад олдохгүй байсан. Энэ хоёр компаниас нийтдээ 107.8 сая төгрөгний зөрүүг тодруулах боломж бүрдээд байна. 318.7 сая төгрөг үлдэж байна. Үүнээс гадна 200 шахам сая төгрөгний зөрүүг тодруулах боломж байгаа. Тэгэхээр нийтдээ 121.5 сая төгрөгийн шийдвэрлэгдээгүй зөрүү үлдэхээр байна.

**Н.Даваацэдэв:** Санхүүгийн тайлан, татварын тайлангуудаас, тухайлбал лицензтэй компаниудаас шууд ийм хавсралт тайлан нэмж гаргана гээд автоматаар ОУИТБС-ын тайланг гаргачих бололцоо байдаггүй юм уу?

**Н.Эрдэнэцог:** Энэ ОУИТБС-ын тайлан нь мөнгөн суурьтай. Компаниуд аккруэль суурьтай нягтлан бodoх бүртгэл дээр санхүүгийн тайлангаа гаргадаг. Тийм учраас суурийн энэ зөрүүнээс шалтгаалаад шууд тэнд байгаа тоон мэдээллийг ииш нь шууд хийчих боломжгүй юм.

**Б.Дэлгэрбаяр:** Хураамж, үйлчилгээний хөлс бага байна гээд хасах санал тавьж байгаа юм байна. Манай компанийн хувьд сансрын антений хураамж, үйлчилгээний хөлс гээд жилд 14 сая төгрөг төлдөг. Тоног төхөөрөмж оруулж ирэхэд гаалийн үзлэг, үйлчилгээний хөлс гээд их мөнгө гардаг. Энэ асуудал дээр үйлчилгээний ангиллаар нь болох уу, эсхүл тооных нь босгоор нь болох уу ямар нэгэн гарц гаргахгүйгээр бүр хасчихвал арай л болохгүй байна?

**Н.Эрдэнэцог:** Зөв л дөө. Материаллаг түвшинд босго тогтоох хэрэгтэй. Энэ асуудлыг Ажлын хэсэг шийдвэрлэнэ. Дараагийн нэгтгэлд үүнийг анхаарна байх.

**Ц.Цэгц:** Уулын ажлын төлөвлөгөөний тоонууд Ашигт малтмалын газраар баталгаажсан тоо мөн үү. Бид энэ асуудал дээр нилээд нухацтай хандаж ажилладаг. Биднийг заримдаа хүнд сурталтай гэдэг. Энэ талаар?

**Б.Мэндбаяр:** Ашигт малтмалын газарт гаргаж өгдөг тайлангийн маягт байгаа. Ашигт малтмалын газрын хүлээн авсан, гарын үсэг зураад баталгаажсан тэр тайлангаасаа компаниуд гаргаж өгсөн. Хуулбараа ирүүлсэн. Харин зарим нэг нь өөрсдөө гаргасан юм бий гэхдээ. Хэдхэн юмаа.

**Б.Долгор:** Ашигт малтмалын газрынхан уулын ажлын төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлттэй холбоотой асуудлаар та нар тодорхой хариулаач? Энэ дээр нэлээн олон асуудлууд гарч ирээд байна шүү дээ?

**Ц.Цэгц:** Уулын ажлын төлөвлөгөөг ОУИТБС-ын төлөвлөгөөтэй харьцуулан судалгаа хийж байгаа. 2009 оны тайланг хүргүүлсэн. 2010, 2011 оны тайлан дээр

ажиллаж байна. ОУИТБС-ын тайлан ба манай тайлан хоёр зөрдөг байж ч магадгүй, таардаг ч байж магадгүй.

**Б.Долгор:** Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэйгээ хэр зэрэг ажилладаг юм бол? Жишээ нь компаниудын мэдээллийн 50 хувь ерөөсөө шинэчлэгдээгүй байна шүү дээ. Хууль тогтоомжийн биелэлт, мэдээ тайлан зөв авах, бодит байдлыг хангах талаас гэх мэтээр танайх юу хийдэг юм бэ? Мэдээ тайлан дээрээ ямар үнэлгээ хийдэг юм бэ?

**Ц.Цэгц:** Жишээлбэл энэ тайланд орсон хаягийн бүртгэл их хуучирсан байна гэж байна. Аж ахуйн нэгжүүд өөрсдөө байршлаа шинэчлэгдэх тохиолдолд бидэнд мэдэгдэж хаягаа өгөх үүрэгтэй. Бид энэ асуудал дээр арга хэмжээ авч байгаа.

**Н.Дорждарь:** Брэйвхарт ресорсиз, Монполимет, Монгол газар зэрэг компаниуд 2-3 жил дараалан тайлан гаргаагүй гэж байна. Гэхдээ нэгтгэлд орсон байгаа юм байна. Засгийн газрын тайлагнасан дүнг шууд зөрүү гэж үзэж байна уу?

**Н.Эрдэнэцог:** Зөрүү гэж үзэж байгаа. Тайлан гаргаагүй учраас шууд зөрүү үүснэ. Үүнийг анхны зөрүү гэж тооцдог. Засгийн газар нь тоотой. Компаниуд нь тоогүй, түүнийг шийдвэрлэхээр ажиллана. Нөгөө компаниуд руу холбогдоно. Мэдээллээ авна. Шийдэхийг нь шийдээд, шийдээгүй зөрүүг нь тайлбарлана.

**Б.Долгор:** Өөр асуулт тавих хүн байна уу? За байхгүй бол санал хэлцгээ

**Н.Алгаа:** Төлбөр, хураамжийн тухай би их олон удаа ярьж байгаа. Энэ үнэн. 22-ын товчоогоор гараад 500 төгрөг, Дарханд очоод 500 төгрөг, Эрдэнэт-д очоод 500 төгрөг гээд ингээд цуглуулаад байдаг. Тэгэхээр тэмдэгтийн хураамжийн тухай хууль гэж байгаа. Тэр хуулинд хуульчилсан төлбөр, хураамжийг маягтад багтаан гэхээс биш, зүгээр орон нутагт авдаг жижиг хураамжийг багтаана гэвэл бид тавьсан зорилгоосоо холдоод байна. Тэгэхээр ОУИТБС-ыг том утгаар нь харж байгаа, авилга, коррупци талаас нь. Тэмдэгтийн хураамжийг хуульчилсан тийм хураамж, төлбөрийг жагсаалтаас харж байгаад оруулъя. Тэгэхгүй бол бидний болон аудитын ажлыг хойш татаад байх юм байна. 1800 компани гэхэд л ихэнх нь хайгуулын компани, тэгээд зардал гаргаад, тайлан гаргаад явж байгаа шүү дээ. Тодорхой биш юмны хойноос хөөцөлдөөд цагаа их үрж байна. Байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудал Санчаачилгын үндсэн зорилт биш гэх мэтээр би үүнийг өөр байдлаар зохицуулагдах ёстой гэж бодож байна. Тусгай зөвшөөрөл ч гэсэн, тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй бол шууд л цуцлагдах ёстой, харин цуцлагдаагүй бол яагаад гэсэн асуудал үүсээд явж байх ёстой. Орон нутагт мэдээллийг хүргэх хэрэгтэй. Орон нутагт хэрэгжиж байгаа төслүүдийг хамруулах хэрэгтэй байна. Тиймээс тайланг цомхон болгох хэрэгтэй. Хуучин цагийн арга хэлбэр лүү орох гээд байна.

**Л.Даваацэдэв:** Өмнөх тайлан болон энэ саяын тавьсан илтгэлээс харахад энэ нэг л том судалгааны ажил хийсэн юм шиг харагдаж байна. Зорилго санаа нь бол уул уурхай хөгжиж байгаатай холбоотой хөрөнгө мөнгөний урсгал буруу зөрүү

уул уурхай хөгжик байгаатай холбоотой хөрөнгө мөнгөний урсгал буруу зөрүү замаар явчих вий, үүнээс л сэргийлэх, ил тод байлгах ийм л зорилготой гэж ойлгоод байгаа. Гэтэл тэртээ тэргүй гаргадаг юмийг гаргуулаад байгаа нь компаниудыг төвөгшөөх хандлага руу хөтлөөд байна. Аудитор нь компаниуд хойрго байна үнэлгээ гаргасан байна. Аргагүй юм байна. Тэгэхээр 70 хувь нь дунд авахаас өөр аргагүй шүү дээ. Ил тод байдлын ажил маань анхныхаа зорилгод нийцэж байгаа эсэхэд эргэлзээ төрөх болов. Шалтгаан нь хууль эрхзүйгээс эхлээд олон зүйл байж магадгүй, ийм учраас бидний ажил нэг судалгааны ажил болоод байх шиг байна. Судалгааны хувьд олон асуудлыг нэгтгэсэн сайн ажил байна. Харин гол зорилтоосоо хазайгаад байна гэж үзэж байна.

**Б.Батболд:** Би Алгаа гуайтай санал нийлэхгүй. Өмнөх тайлангууд баахан тоо байдаг байсан шүү. Одоо байгаль орчны нөхөн сэргээлтийн талаар оруулж өгсөн маш чухал. Энэ бол орон нутгийн иргэдэд ил тод болж байна шүү. Монполимет маш сайн хийдэг, гэтэл тайлангаа өгөхгүй хойрго байгаа нь ил тодоор гарсан нь маш чухал. Энэ чигээр нь явуулах хэрэгтэй байна.

**Т.Цэцэгням:** Засгийн газрын тайланд орхигдуулж тайлагнаасан 17.3 хувь. Энэ дотор юу байгаа вэ гэвэл орон нутагт хураадаг мөнгийг Засаг даргын Тамгын газрууд өөрсдийнхөө нэрээр оруулснаас энэ асуудлууд үүссэн. Ийм асуудал урьд нь байсан, уламжлагдан ирсэн асуудал энэ удаагийн тайланд мөн давтагдаж байгаа. Яагаад гэвэл процесс нь нэг учраас үргэлжлээд яваад байна. Бид энэ асуудлаар оны эхэнд аудит хийж эхлэхэд албан тоот бичээд татварын албадуудадаа бүгдэд нь хандаад ийм ийм алдаа гарсныг мэдэгдсэн. Зарим нь алдаа биш, процесс нь зөв үйл ажиллагаа. Гэвч олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, түүний тайлагналтай холбогдоод задалж тодруулах шаардлагатай болсон. Тухайлбал, улсын тэмдэгтийн хураамж байна. Энэ улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулин дээр юу гэж заадаг вэ гэхлээр хураамж хураагч байгууллага нь өөрөө мэдээ тайлангаа гаргахаар хуульчлагдсан байдаг. Тэгэхлээр энэ дагуу татварынхаа програмыг хийсэн, жишээ нь шүүх, улсын бүртгэл гэх мэт энэ байгууллагын нэрээр олсон орлогыг нь тооцоод аль байгууллагаас хэн нь хэдийг хийв гэдэг нь програмчлагдаагүй тайлан юм. Тэгэхлээр энэ асуудлууд нь хүндрэл үүсгэж байсан. Одоо ч хэвээрээ цаашид өөрчлөгдөхгүй л бол хэвээрээ үргэлжилнэ. Энэ бол яг програмын алдаа биш манай хувьд зөв. Энэ тухайд програмчлалд өөрчлөлт оруулах асуудал, өөрчлөлт оруулахдаа олборлох үйлдвэрлэлийн тайлантай холбогдуулж өөрчлөлт оруулах асуудал яригдана. Манай хууль хэрэгжүүлэлтийн талаас бол манай програм угаасаа зөв. Тэгэхээр энэ асуудалтай уялдуулж программыг олборлох үйлдвэрлэлийн тайлан, мөн веб хандлагатай, дээрээс нь татварын албаны мэдээллийн баазаас мэдээллээ татдаг ийм программ хийе гээд бид бодлогын даалгаврыг хийгээд бас өргөн хүрээтэй, (манайх эрдэс баялагийн хэлтэстэй болсон), эрдэс баялагын сан гэдэг тийм програмтай болъё гээд бодлогынхoo даалгаврыг өргөн хүрээнд хийгээд үүнийгээ хөөцөлдөөд явсаар байгаад тендер зарласан чинь тендерт орсон байгууллагууд энэ программ их том, бас хөрөнгө мөнгө нь бага байна гэж голоод хийгээгүй. Мөнгөгүй учраас бид энэ программийг хийж чадахгүй байна. Ийм асуудал үүссэн. Гэхдээ бидэнд программчлах талаас нь хөрөнгө мөнгөний туслалцаа өгөх юм бол энэ ажиллагаа

сайжрах боломж байгаа. Хоёрт: нэг татварын илүү төлөлтөөс нөгөө татварыг дутуу төлөлтөд суутган тооцсоныг Засгийн газар тайландаа оруулаагүй гэсэн асуудал тавигдсан байна. ОҮИТБС-ын тайлан бол мөнгөн суурьтай тайлан. Нэг татварын илүү төлөлтөөс нөгөө татварын дутуу төлөлтөд тооцно гэдэг асуудал бол суутган тооцоолол. Өөрөөр хэлбэл урьд онд төлсөн мөнгөнүүдээс дараагийн онд төлөөгүй мөнгийг төлсөн өр хааж байгаа бичилт юм. Өмнөх онуудад маш их зөрүүлж байсан. Манайхан ясан гэхлээр энийгээ төлөлт мэтээр оруулаад ирсэн байсан тийм асуудал гарсан. Бид нар 2009 онд энэ дээр нэлээн запруулсан. Энэ онд бас запруулга хийж яваа. Гэхдээ энэ дээр төлөлтөд суутган тооцсоныг оруулаагүй байна гэхээр мөнгөн дунгээсээ татгалзаж байгаа юм шиг ойлгогдож байгаа. Мөнгөн дунгээсээ татгалзаж байгаа биш гэж сая Эрдэнэцог шинжээч хэлсэн учраас би өгүүлбэр нь буруу орсон юм болов уу гэж ойлгож байна. Ийм байгаа нөхцөлд бид давхардуулан илүү дутуу хаалтыг оруулж болохгүй. Урьд онд төлсөн гээд орсон дүнг дараагийн онд хаалтаар хийлээ гээд оруулчих юм бол өссөн дүнгээ зэрэгцүүлэх боломжгүй, өссөн дүнгээр гаргахад буруу тоо гарна. Тиймээс үүнийг анхааран харах хэрэгтэй.

**Ц.Цэгц:** Энэ 2 тайланг гаргах шаардлагатай бол сайжруулах хэрэгтэй.

**Н.Дорждарь:** Компаниудаар гаргана гэж найдаж байна. Аймгуудаар бас гаргах хэрэгтэй. Ханбогд, Цогцэций суман дээр туршилтын журмаар энэ санаачилга хэрэгжих бололцоотой юу гээд санал тавьсны дагуу тайландаа оруулж өгсөнд талархаж байна. Гэхдээ энэ бол ТАН эвслийн тайлан биш байх л даа. Энэ бол ОҮИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх оролцоог судалж байгаа учраас энэ гарчгуудыг өөрчлөх, сумын түвшинд тайлан гаргах нь санхүүгийн мэдээллийн нэгтгэл талаасаа хэр бодитой боломжтой вэ Ингэж хийх нь зөв үү, буруу юу. Сумын түвшинд гурван талын оролцоотой ийм тусдаа тайлан байх нь зөв үү, эсхүл үндэснийхээ тайланд сумын задаргааг гаргах бололцоог хайх нь зөв үү. Яагаад гэвэл хүн болгон л ярьдаг орон нутагт иргэд мэдээлэл авмаар байна гэдэг, үндэсний тайлан тэр болгон sumaар нь зарлаачихаж болдоггүй ийм асуудал үүсээд байгаа учир энэ дээр өөрсдийнхөө мэргэжлийн зөвлөгөөг өгөөч ээ гэж хүсэх байна. Гуравдугаар бүлэгтэй холбоотой нэг асуудал байна. Уул уурхайн салбарын өнөөгийн байдлын талаар энд тэндээс статистикийн газрын мэдээлэл аваад тавьсан байх юм. Миний хувьд юу гэж бодож байна гэвэл гадны хүнд англи тайлан уншиж байгаа хүнд сонин байж магадгүй. Тэрнээс биш жишээ нь хэдэн компани байдаг ч гэдэг юм уу, эсхүл тийм бүтээгдэхүүн үйидвэрлэдэг, алт тэдийг үйлдвэрлэдэг, жонш тэдийг үйлдвэрлэдэг гэх мэт баахан мэдээлэл байгаа юм л даа. Энд байгаа мэдээллийг Санчаачлагын тайлантай холбож З дугаар бүлэгт жаахан редакц хийвэл их сонирхолтой болох юм болов уу. Хооронд нь жаахан уялдуулж өгөхгүй бол өөр нэг байгууллагын тайланг хуулаад тавьсан юм шиг харагдаад байна. Үүн дээр эргэж харах бололцоо байна уу. Хураамж, үйлчилгээний хөлсний талаар яригдаж байгаа материаллаг байдлын тал дээр өөр олон зөвлөмж гаргаж байна. Энэ дээр ажлын хэсэг байгуулаад энэ асуудлыг шийдэх боломжтой гэж хувьдаа бодож байна. Ялангуяа тайланг шууд нэгтгэгч байгууллага дээр хүлээж авдаг, нэгтгэгч байгууллагад хүргэдэг асуудлыг бид анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд олон улсын шаардлагага байгаа. Өнөөдөр Цолмон гуай дээр цугларч байна. Уг нь аудитор дээр шууд очих мэдээлэл Цолмон гуайгаар

дамжиж орж байгаа. Тэгэхлээр энэ дээр процесийн асуудал байгаа учраас энийг яаж шийдэх вэ гэдэгт анхаармаар байна. Жижиг сажиг асуудлууд бас байна. Жишээ нь, Оюу толгойтой холбоотой урьдчилгаа төлбөр юм шиг байгаа юм, энгийн хүн уншихад огт ойлгохгүй байх жишээтэй бичигдсэн. Өөрөөр хэлбэл урьдчилгаа төлбөрийн хэд нь төлөгдсөн, хэд нь төлөгдөөгүй гэх мэт асуудлыг эргэж харах хэрэгтэй байна. Жишээ нь 100 сая төгрөг юмуу 100 сая доллар юмуу, 50 сая доллар орсон юмуу ороогүй юмуу, тэрийг нь би тэр хэсгээс уншаад ойлгохгүй байгаа юм гэх мэтээр сайн эргэж нягтлах хэрэгтэй байна.

**Д.Цэрэнжав:** Жижигхэн санаа нэмье. Зөрүүг тохируулсан, шийдвэрлэсэн гээд бичих гээд байна л даа. УБ аудит корпораци ажлаа явуулахын тулд тулгамдсан асуудлыг шийдэж байгаа юм байна л даа. Олон нийтэд ийм үгээр хүрэхээр буруу ойлголт төрүүлээд байж магадгүй, дутуу төлөгдсөнийг зөв төлүүлээд, буруу зөрүү оруулсныг оруулаад, ингээд явсан гэж ойлгогдох вий, урд нь бас энэ талаар ярьж байсан. Тийм учраас эцсийн тайландаа арай өөрөөр өөр нэр томъёо хэрэглэвэл зүгээр юм уу гэж бодож байна

**Н.Дорждарь:** Компаниудтай ямар ямар хүндрэл учирсан гээд шалтгаанууд тоочсон байна л даа, жишээ нь, жирэмсний амралтаа аваад явсан гэдэг ч юм уу. Би аудиторыг ойлгож байна л даа, иймэрхүү бодит шалтгаанууд байгаа гэдэгт. Гэхдээ энэ бол ерөөсөө компаниуд өөрсдөө Санаачлагад хэрхэн хандаж байгаагаа харуулж байгаа зүйл ш дээ. Аудитор нягтлан бодогч байхгүй гээд нягтлахгүй бол тэр компани л энэ санаачилгыг дэмжихгүй байна гэж би ойлгож байна л даа, хариуцлагагүй хандаж байна. Тэр шалтгааныг илүү бодитой амьдралд оруулмаар байна. Нягтлан бодогч гэдэг бол тэр компаний л хариуцлага. Компани хариуцлага байхгүй байна гэдгийг хэлэх хэрэгтэй байна. Энэ тал дээрх янз бурийн нарийн шалтгаануудыг өөрчлөх бололцоотой юм болов уу гэж бодож байна.

**Э.Оюун:** Газрын тосны 10 компани энэ тайланд хамрагдсан байгаа. Үүнээс 2 нь олборлолт явуулж үлдсэн нь хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ тайлангаас харахад бүх 10 газрын тосны компаниуд олборлолт хийж байна гэж ойлгогдож байна. Тиймээс 2 нь олборлолт, бусад нь хайгуул хийж байгаа гэж тодруулж тодорхой болгож өгөөч гэсэн санал тавьж байна.

**Э.Сумьяа:** Аудитын урьдчилсан дүнг сонслоо. Аудитын компанийг шахаж болдог юм бол уу мэдэхгүй байна. Гэхдээ л бид их шахаж байгаа. Яагаад гэвэл төсөв хөрөнгө нь хаагдчих гээд тиймээс арай л болоогүй байхад нь 16-наар тасалбар болгоод ажлын хэсэгт дүнгээ оруулъя гэж тохирсон. Тэр дагуу оруулсан. Аудитын компани сайн ажиллаж байна. бидний зүгээс ч тусалж дэмжиж байгаа. Гэхдээ тодруулга дотор зарим нь хандив гэж бичсэн байсан. Энэ нь хандив биш, зардлаа хандив гэж бичсэн байсан. Тэрийг эргэж хараарай. Мэндбаярт хэд хэдэн зөвлөмж өгсөн байгаа. Үг үсэг талаас нь, хэлбэр дурс талаас нь харахаар юм уу тэрийг яриад яахав. Аудитын консорциумын хувьд сайн ажиллаж байгааг дахин хэлмээр байна. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны тусламжаар хэрэгжиж байгаа төслийг үр дүнтэй болгохын тулд бид өнөөдрийнхөө байдлыг хамгийн сайн гаргаж байж, тэр төслийн үр дүнг сайжруулахаар байгаа учраас бид аль болохоор

чадах чинээгээрээ ажиллаж байна гэдгийг хэлмээр байна. Энэ талаас ч гэсэн аудитын компаниуд бидэнд тусалж байгаа. Тэмдэглэлийн төсөл дээр нэг тайлбар хэлье. Та бүхний өмнө энэ тайлантай холбоотой 4 заалт бүхий тэмдэглэлийн төсөл байгаа. 1-р тэмдэглэлийг жаахан засаад та бүхэнд танилцуулах гэсэн юмаа. Одоо тэр тулгалт хийгдэж байгаа “426 сая төгрөгийн” гэдгийг “хавсралтад заасан зөрүүг” гэж өөрчилье. Хавсралтыг Ш.Цолмон хийж байгаа. Хоёрдугаарт: үндэсний зөвлөлийн хуралд оруулах хугацаа тулчихаад байх шиг байна. Тийм учраас “2012 оны 2 дугаар сарын 1-ний дотор” гэж өөрчилье гэсэн саналтай байна.

Ажлын хэсгийн гишүүдээс нэг эрх авъя. 2 дугаар заалтад Аудитын компанид мөнгийг 100 хувь өгье гэж байгаа. Та бид тэмдэгэлийн нэгдүгээр заалтыг тохирьё. Гурав хоногийн дараа 12 дугаар сарын 26 нд тендерийн холбогдолтой бүх мөнгийг Төрийн сан хаах гээд байгаа. Тийм учраас мөнгийг нь аудитын консерциумд төлөө. Харин аудитын консерциум өнөөдрийн тэмдэглэлээр өгсөн үүргийг биелүүлж, эцсийн тайланг Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд тайлагнах үүрэг хүлээж байгаа. Үүнийг гурван талын оролцогчид зөвшөөрөх үү.

**Н.Дорждарь:** Би ганц зүйл нэмж хэлье. Энэ бол эргээд манай өөрсдийн ажлын төлөвлөлт, түүнтэй холбоотой асуудал. Бид урьд нь ярьж байсан яж энэ тайлан жил хагасын дараа гарч байна. Бид жилд нь багтаагаад гаргая гэсэн, энэ жил явсаар байгаад амжсангүй. 2011 оны тайлангийн аудиторыг тэр 2010 ондоо сонгочоод сууж байдаг баймаар байна. Удааширдаг энэ тогтсон циклээсээ гарах хэрэгтэй байна.

**Б.Ганхүлэг:** 2006 оноос хойш Бороо гоулд компани энэ тайланда орж байгаа. ОУИБС-ын тайлан үнэхээр сайжирч байна. Аудитор компани дадлагажиж байна. одоо нэгэнтээ дадлагажаад овоо болоод ирэхээр үүнийг яж хялбар болгох вэ, яж хувийн компаниудад дарамт бага болгох талаар хамтарч бодох хэрэгтэй.

**Н.Баярсайхан:** Тайланг Үндэсний зөвлөлд орохобос өмнө 9.10 дээр тайланг олон нийтэд сурталчлах талаар гэсэн заалт байна. Энэ дээр олон нийт гэдэгт орон нутгийн иргэдийг хэлж байгаа шүү дээ. Энэ хүмүүс рүү чиглэсэн зөвлөмжийг нэмүүхэн оруулаачээ гэж хэлмээр байна. Сурталчилгааны ажил хийснээр илүү үр дүнтэй байлаа гэж байна, компаниудын бизнесийн нэр хүндэд халдах асуудлыг эхэлж байгаа юм байна. Гэхдээ олон нийтэд яж илүү хүргэх вэ? Хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэнд яж үүнийг сурталчлах вэ гэдгийг энэ Санаачлагын тайлан дээр нэмээд оруулж өгвөл их сайн байна гэж хэлмээр байна.

**Б.Долгор:** За баярлалаа, Сумьяа гуайн түрүүний хэлсэн өөрчлөлтийг тэмдэглэлд оруулаад ингээд энэ асуудлаа шийдвэ гэсэн саналтай байна. Хүмүүсийн гаргасан санал зүйтэй байна, ач холбогдлыг ойлгуулах ёстой. Энэ ажлыг хийснээр гурван талд ашигтай байх ёстой. Бид тодорхой хугацааг туулаад туршлага хуримтлуулж байна, сургамжуудаараа ажлаа цаашид сайжруулах учиртай, үр ашгийг нь нэмэгдүүлэх ёстой. Тийм учраас энэ гаргаж байгаа саналуудыг бид хүлээн авах ёстой. Гэхдээ гаргах ёстой зүйлүүдээ бүрэн гаргаж байж энэ ажлын үр ашиг нь гарч ирнэ. Жишээ нь уулын ажлын төлөвлөгөөний биелэлт гэхэд Эрдэс

баялаг, эрчим хүчний сайд маань энэ асуудлыг санал болгоод хийж байгаа ажилтай нь уялдуулж өгье гэдэг ийм чиглэлийн санал санаачилга гараад тайланд ороод явж байгаа юм. 2010 оны тайлан дээр ийм байдлаар гараад, цаашдаа 2011 оны тайлан дээр ямар нэмэлт, хасалт юу хийх вэ гэдгийг бид явцын дунд шийдээд явах бүрэн бололцоотой гэж ойлгож байгаа. Нөгөө нэг асуудал бол олон нийтэд энэ асуудлаа сурталчлах ойлгуулах, хүргэх, ялангуяа орон нутгийн иргэдэд хүргэх гэх мэтэд анхаарал тавьж ажиллаж байгаа. Ажлын албанад олон нийт, харилцааны ажилтан мэргэжилтэн авсан. С.Батбаярыг танилцуулав. Та бүгдтэй ажиллана, нөгөө талаас энэ ажлын үр дүн илүү гарч ирнэ гэж бид тооцож байна. Хугацааны талаар тайлан, хороогоо байгуулах, сонгон шалгаруулалт явуулахаас өгсүүлээд тодорхой хугацаануудаа өөрчлөхтэй холбогдсон зүйлүүд яригдлаа. Үүнийг Ажлын алба сайн анхаарах хэрэгтэй.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Монгол Улсын 2010 оны аудитын нэгдсэн тайлангийн урьдчилсан дүнг сайшааж, тулгалт хийгдэж байгаа хавсралтад заасан зөрүүг 2012 оны 1 дүгээр сарын 15-ны дотор эцэслэн шалгаж, эцсийн тайланг Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулахыг Аудитын концерциумд зөвлөж, улмаар эцсийн тайланг 2012 оны 2 дугаар сарын 1-ний Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулахыг Ажлын хэсэг (Ахлагч Б. Долгор)-т зөвшөөрөв.

2. Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайланг хэлэлцээд Харт нойрс лтд, Улаанбаатар аудит корпорацийн гэрээт ажлын төлбөрийг ондоо багтаан бүрэн барагдуулахыг Ажлын албанад (Зохицуулагч Ш. Цолмон) зөвшөөрөв.

3. Монголын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн эцсийн тайлан гарч, Ажлын хэсгийн гишүүдэд дахин танилцуулсны дараа ОҮИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газарт явуулах нь зүйтэй гэж үзэв.

4. Монголын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайланд олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл бүхий бүх компаниудын нэрсийг оруулах, ОҮИТБС-ын тайланг гаргасан гаргаагүйгээр нарийвчлан гаргаж өгөхийг Ажлын албанад даалгав.

## **II. ХЭЛЭЛЦСЭН нь: Тайлан гаргах эрхзүйн үндэс болон практик**

Тайлан гаргах эрхзүйн үндэс болон практикийн тухай Далайван аудит компанийн ерөнхий захирал Б.Жигдэн танилцуулав (Үзүүлэнг хавсаргав).

Б.Жигдэн-Манай улсын санхүүгийн жил 12 дугаар сарын 31-нээр тасалбар болдог. Тэгээд 1 дүгээр сараас 2 дугаар сарын 25-н хүртэл нэгдсэн тайлан гаргах, тушаах ийм процесс улсын хэмжээнд явдаг. 2 дугаар сарын дундаас эхлээд 4 дүгээр сарын 30-ны хооронд аудитын ажлууд улсын хэмжээнд явдаг. Сангийн яам дээр Засгийн газрын балансыг нэмэхээр төрийн байгууллагууд дээр 3 дугаар сарын 15-наас 4 дүгээр сарыг дуустал хийгдээд Үндэсний аудитын газар төсвийн байгууллага, төрийн үйлчилгээний томоохон байгууллагын нэгтгэлийн аудитын ажил бас 3-4 дүгээр саруудад эрчимтэй явагдах мэтээр яваад 6 дугаар сарын үед

Засгийн газрын санхүүгийн тайлан Засгийн газрын танхим, УИХ руу ордог. Иймэрхүү дүр зураг харагдаад байдаг. Эндээс би та бүхэнд ямар зүйлийг хэлэх гээд байна гэхлээр санхүүгийн жил гэдэг юмыг Монгол Улсад бий болгомоор санагдаад байгаа юм л даа. Монгол Улс өөрөө их эрс тэс уур амьсгалтай 4 улиралтай. Энэ улирлаа дагаад барилгын, уул уурхайн салбар газар хөлдөхөөр зогсдог. Мал, аж ахуй, газар тариалангын салбар тариагаа хурааж аваад зогсчихдог. Тэгээд л 12 дугаар сарын 30-наар уралдаад болсон болоогүй баахан баланс тайлан гаргадаг. Ингээд сүүлд нь баахан зөрүү буруу гардаг, тэрийгээ тушаадаг. Төрийн байгууллага хүлээж аваад тооцоо хийдэг. Татвар шимтгэл гээд д янз бүрийн тооцоо хийнэ. Дараа нь аудит нь шалгалт хийж байгаа гэж хэсэг баахан юманд шахагддаг. Ингээд эцсийн дундээ улс ардын ахуйн, нийгэм эдийн засгийн тоон мэдээ ийм хачин юм гардаг. Энийг хэлье гэж бодсийм. Өнөөдөр Монгол Улс нягтлан бodoх бүртгэлээ дэлхий нийтийн стандартын дагуу акруэл-ээр бэлдэж акруэл зарчмаар явж байгаа. Тийм учраас энэ ИТБС-ын тайланг олон улсын мэргэжлийн байгууллагуудтай ярьж цаашдаа акруэл суурь руу оруулж юм хийвэл ясийм бол гэсэн нэг том санаа байгаа юм. АНУ, Англи, Япон гэх мэт өндөр хөгжсөн энэ том гүрнүүд яагаад 4 дүгээр сарын 1-нд санхүүгийн жилээ тодорхойлоод явж болоод байна. Энэ чинь олон жилийн туршлага, энэ олон өмчийн системд явж ирсэн улсууд юм. Бид балансан дээрээ баахан хойшлогдсон зардал, хойшлогдсон орлого гээд баахан юм биччихдэг. Ингэхлээр баланс тайлан үндсэндээ үндэслэл сайтай болж чадахгүй байна. Ийм учраас бид цаашдаа акруэл суурьтай тайланг бэлтгэх болон санхүүгийн шинэ жилтэй болох асуудлыг анхаарах хэрэгтэй юм.

### Б.Долгор: За асуулт байна уу?

**Э.Сумьяа:** Олон улсын дүрэм та бүхэнд тараасан байгаа. Энд 12 дугаар шаардлага дээр “Компанийн тайлан нь олон улсын стандартын дагуу аудитлагдсан тоон үзүүлэлтийн дагуу байхыг Засгийн газар хангана” гэж заасан. Дүрэм 7 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн байгаа. Өмнө нь ажлын хэсгийн хуралдаан дээр тайлан гаргах хуулийн хугацааны талаар бүртгэл, санхүү, аудитын хуулиудад хэрхэн заасныг би ярьж байсан. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-т заасан хугацааг баримтлан гэж ажлын хэсэг тохирч ирсэн. Үүнээс болж тайлангийн зарим зөрөөг бид өөрсдөө үүсгээд байгаа. Энэ нь тайлан гаргах хугацаанаас болсон. Олон улсын дүрэмд заасан шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Цаашид хуулийн төслийн багт санаа өгөх зорилгоор бид харилцан ярилцаад 40 гаруй жил санхүүгийн салбарт ажилласан Б.Жигдэн гавьяатаар дээрх хуулийн харьцуулалтын судалгааг хийлгэж Ажлын хэсэгт танилцуулж байгаа юм. Одоо бид хуулин дээр ажиллана. Тайлан гаргах хугацааг тодорхой болгохгүйгээр олон улсын дүрмийн шаардлагыг биелүүлэх боломжгүй, бид энэ зөрүүний тухай ярих асуудал байсаар байна. Байдал ийм болчихоод байна. Энэ олон хуулийг харвал яг эцсийн аудитаар баталгаажсан тоо үзүүлэлтэй тайлан гаргах хугацаа 4 дүгээр сарын 30 байгаа. Та нар хараарай. Компаний тухай хуулин дээр. Компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ын шийдвэрээр хуралдуулж санхүүгийн тайланг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор батална. Үүнээс хойших тоо аудитаар баталгаажсан тоо гэж явах гэж байгаа юм. Тэгэхээр бид Ашигт малтмалын тухай хуулиар одоо явж байгаа. Бид

тайлан гаргах хугацааг 3 дугаар сар, 2 дугаар сарын 15 гээд бид шахчихаж байгаа юм. Тэгэхээр дандаа аудитаар баталгаажаагүй тоо явж байгаа юм. Бид, оролцогч гурван тал нэг ойлголттой болох ёстай. Энэ зорилгоор би энэ мэдээллийг хийлгэсэн юм. Энэ мэдээлэл та нарт хэрэгтэй. Засгийн газрын байгууллагын хүнд ч хэрэгтэй, аж ахун нэгжийн хүнд ч хэрэгтэй, төрийн бус байгууллагын хүнд бас хэрэгтэй. Монгол Улсын 5 удаагийн тайлан гарахад энэ асуудал үнэхээр батлагдаж байна. Бид буруу тоон дээр хүнийг зовоогоод ажиллуулж байна. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн шинэ хуулийн төслүүд боловсруулахад үүнийг анхаараасай гэж бид ярьж байгаа юм. Нэгэнтээ бид Ашигт малтмалын хууль зөв бусад нь буруу гэж хэлж чадахгүй, 2012 онд ажлын алба 2-3-н сургалт явуулъя гэж Дэлхийн банкны зөвлөхтэй, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа Далай ван аудитын байгууллагатай ярьж байгаа. Тэр нь юу вэ гэвэл Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орохгүй юм чинь ирэх жил тавьсан зорилтоо хэрэгжүүлэхийн тулд тайлан гаргах компаниудын тоог нэмнэ. Тиймээс сургалт хэрэгтэй байна. Гэтэл Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн шугамаар хэрэгжих гэж байгаа сургалт 4 дүгээр сарын сүүл, 5 дугаар сар хавьцаа хийгдэх гэж байгаа. Тэгэхээр бид ямар ч сургалтгүй болчих гээд байна. Энийг та бүхэн шийдэж өгөх хэрэгтэй. Тэмдэглэлийн 1 дүгээр заалт дээр байгаа тэмдэглэл дээр. Цолモン, Энхзаяа, Жигдэн гуай болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн зөвлөхүүдтэй яриад байгаа юм. Манайх дандаа жилээс жилд, тайлангаас тайланд ахисан үзүүлэлттэй байгаа. Тийм болохоор бид тавьсан зорилтоо биелүүлнэ. Тэгэхээр энэ 3-н удаагийн сургалт хийх үү байх уу? Үүнийг ажлын хэсгийн гишүүд хийнэ, эсхүл хэрэггүй гэдгийг хэлэх хэрэгтэй байна. Бид уул өөд явж байгаа шүү дээ, ирэх жил нэг жоохон буучих гэсэн дүр зураг харагдаад байна.

**А.Батпүрэв:** Үүнтэй холбоотой санал хэлье. Хөтөлбөр дунд дараагийн асуудал гээд орсон байгаа АСИ байгууллагын хийсэн зөвлөмж гэж байна. Сумьяа гуайн хэлсэн логикоор үүнтэй зайлшгүй энийг хөндөж ярихгүй бол болохгүй нь. Энэ байгууллагын хийж байгаа ажил миний ойлгосноор олон улсын компани консалтинг хийж байгаа гэж ойлгож байна. Үүнд багагүй хэмжээний мөнгө төлж байгаа байх. Тэд нар энэ санхүүгийн орчинд, өөрөөр хэлбэл Далай вангийн нэгтгэсэн байгаа энэ санхүүгийн орчинд, одоо бид нар хууль хийвэл ямар хууль гаргаж энэ тайлангийн процесс нь ямар цаг хугацаатай, ямар үе шаттай явагдах вэ гэдгийг боловсруулсан байх. Аль эсхүл нэмэлт хууль гаргахгүй, хуулинд нэмэлт, өөрчлөлт байдлаар хийнэ гэвэл энэ дээр ийм ийм нэмэлт, өөрчлөлт хийгдээд энэ дунд нь ингэж ажиллаж болох юм байна гэсэн ийм зөвлөмж гарах ёстай байх. Одоо энэ танилцуулгад тараасан байгаа байдлаас үзэхэд EITI гэж баахан зааж байснаа, төгсгөлд нь 2-3 хан сонин дүгнэлт тавиад нэг бол хуультай болъё, нэг бол газрын хэвлийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулъя, нэг бол бусад бүх хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулъя, тэгснээ за ерөөсөө хуультай болсон нь дээр юм байна гээд л. Энэ нь зөвлөмж өгөхийн төлөө энэ байгууллага ажиллаад, бид дараа нь энийг асуудал болгож хэлэлцэхээр болчилоод байна. Далай ван, Улаанбаатар аудит мэдэж байна ш дээ, яг энэ орчинд хууль хэрвээ гарахгүй бол энэ хуулийн орчинд яж ажиллаж, яж тайлангаа ямар цаг хугацааны графикаар гаргах, хэрвээ хууль гарвал хуулийн хугацаа нь ийм байна шүү гэдгийг гаргуулаад дээр нь нэмээд санхүүгийн

тайлангаас гадна хуулинд тусгах ёстой оролцож байгаа талуудын үүрэг хариуцлага, гэх мэт. Энэ юмнуудыг ингээд хуулийн төсөл болгоод ч юм уу цаашаа явчихмаар байна.

**Н. Алгаа:** Хугацааны тухай яриад байна даа. Санхүүгийн жилийг 12 дугаар сарын 31-нээр үү? 4-р сарын 1-нээр дуусгах уу?. 4-р сарын 1-нээр дуусаад дахиад нэг улирлын дараа тайлан гаргана гээд хойшоо явчихна ш дээ. Энэ бол хоцрогдол. Бүгд 12 дугаар сарын 31-нд тайлан гаргах бололцоотой болчихож байгаа ш дээ. Тэр лүү явахын оронд санхүүгийн жилээ өөрчлөөд дахиж шинэ юманд бүгдийг дасгах гээд л. Миний хувьд холбогдох хуулиудад өөрчлөлт оруулаад хурдан тайлан гаргадаг хугацааг нь шахаж өгөх ёстой.

**Т.Цэцэгням:** Ноднин би энэ ажлыг 4 дүгээр сард авсан. Намайг ирэхэд 3-н сарын 15-нд Засгийн газрын нэгдсэн тайланг тайлагнах ёстой гэсэн чинь нэг ч байгууллагын тайлан ирээгүй байсан. 4 дүгээр сар гаргаад ажил авахад 40 хэдэн хувьтай байсан. 2 дугаар сарын 10-15 нь аж ахуйн нэж байгууллагууд тайлангаа татварын албанд өгдөг л хугацаа, 4 дүгээр сараас баталгаажуулалт хийгддэг. Энэ хооронд маш их ажиллагаа явагддаг. 2 дугаар сарын 15-нд манайд тайлангаа гаргаж ирүүлнэ гэхээр энэ хэрэгжихгүй. Жилийн жилд ийм байсан байна. Би ОУИТБС-ын тайлангын хугацааг жаахан хойшлуулвал яасийм гэсэн саналтай байна.

**Б.Долгор:** За одоо шийдвэрээ гаргая. Шийдвэрийн төсөлтэй та бүхэн танилцсан байх.

**Э.Сумьяя:** Тэгээд сургалт явуулах юм уу?

**Б.Долгор:** Сургалт явуулна. Гишүүдээс одоо санал авъя энэ талаар.

(Гишүүд гар өргөн санал өгч сургалт явуулахыг дэмжив)

**ШИЙДВЭРЛЭСЭН** нь: 1.ОУИТБС-ын 2011 оны тайлан гаргах аргазүйн зөвлөгөө өгөх, тайланг чанартай гаргахын тулд 2012 оны эхэнд 3 доошгүй удаагийн сургалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн арга зүйг ашиглан зохион байгуулахыг Ажлын албан (Зохицуулагч Ш. Цолмон) зөвшөөрөв.

2. Сургалт зохион байгуулах, ялангуяа компаниудын төлөөллийг хамруулах чиглэлээр Татварын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Цөмийн энергийн газартай хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэв.

Б.Долгор-дараагийн хэлэлцэх асуудалдаа ороё.

**III. ХЭЛЭЛЦСЭН нь:** Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2011 оны аудитын нэгтгэл тайлан гаргах байгууллагын сонгон шалгаруулалтын удирдамж, Үнэлгээний хорооны тухай

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон сонгон шалгаруулалтын удирдамжийн талаар товч мэдээлэл хийв. (Сонгон шалгаруулалтын удирдамж болон үнэлгээний хорооны гишүүдийн нэрсийг хавсаргав)

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Монголын байгаль орчны ТББ-ын иргэний зөвлөлийн гишүүн Б.Батболд, Уул уурхайн ассоциацийн нягтлан бодогч Б.Оюунболов, Ашигт малтмалын газрын ахлах мэргэжилтэн Ц. Цэгц нарыг оруулах санал гаргав.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2011 оны аудитын нэгтгэл тайлан гаргах байгууллагын сонгон шалгаруулалтын удирдамжид хуралдаан дээр ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусган зөвшөөрөв.

2. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Н.Алгаагийн оронд Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн нягтлан бодогч Б.Оюунболовыг оруулах, Монголын байгаль орчны ТББ-ын иргэний зөвлөлийн гишүүн Б.Батболд, Ашигт малтмалын газрын ахлах мэргэжилтэн Ц. Цэгц нарыг нэмж оруулж, бүрэлдэхүүнийг батлан ажиллуулахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Долгорт зөвшөөрөв.

3. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2011 оны аудитын нэгтгэл тайлан гаргах байгууллагын сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу зарлан Үнэлгээний хороотой хамтран явуулахыг Ажлын албанд (Зохицуулагч Ш. Цолмон) зөвшөөрөв.

**IV.ХЭЛЭЛЦСЭН нь:** Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох, авах арга хэмжээний тухай

**Э.Сумьяа:** Батпүрэвийн гаргасан саналтай нэг байна. Монгол Улсын ОҮИТБС-ын хууль, тогтоомжийг бий болгох, өөрчлөх гээд баахан мөнгө үрчихээд ийм л тайлан гаргаж байгаа байхгүй юу. Материалын харааар Монгол Улсын хууль, тогтоомжийг өөрчлөх гээд байгаа юм уу. Гэтэл манай салбарын өнөөгийн байдлыг харуулах ёстой байсан байхгүй юу. Гэтэл юу вэ гэхээр үзэл баримтлал батлуулах гээд бүх хууль дээр байдаг юмыг аваачаад тавьсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас аваад тавьсан байгаа. Тэгээд сүүлд нь баахан явж явж даасан хууль гаргана гэнээ. Бие даасан хуульд манай ажлын хэсэг гарваад явж чадаагүй байгаа шүү дээ одоо. Юутай тулсан бэ гэхээр бусад бүх хуультай зөрчилдсөн байгаа юм. Надтай ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хувиар уулзсан. Би бүх хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулъя гэсэн санал өгсөн. Бие даасан хууль гарч ирээд батлуулахгүй бол энэний хариуцлагыг ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хувьд би хүлээхгүй. Энэ тухайгаа ажлын хэсгийн гишүүдийн өмнө хэлчихье. Долгор даргатай бас уулзсан. Тэгээд судлаад үзээчээ. Бие даасан бидний хуулийн төсөл

явахгүй байна гэж бас дарга хэлсэн. Ингээд хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах зарим хувилбарууд явж байгаа. Иймэрхүү байдалтай болчиоод байна. Гэхдээ хуулийн төслийг эдний төсөл гаргана л даа. 2-т Монголын үндэсний зөвлөх нь манай ажлын хэсгийн хуралдаан ирэхгүй байгаа. Ажлаа тайлагнахгүй байна. Энэ бол юу гэхлээр үнэхээр хариуцлагагүй хандаж байгаагийн илрэл. Хэрвээ Монголын хүн ингэж асуудалд хандах юм бол бид хуулийн Үндэсний зөвлөхийг солих ёстай.

**Б.Долгор: Ч.Энхзаяаг уу?**

**Э.Сумьяа:** Үгүй үгүй. Хуулийн зөвлөхийг нь. Энэ бол Монгол хүн үндэсний зөвлөх нь ажиллах байтал. Энэ тайлан бол гадаадын зөвлөхүүдийн тайлан. Ингээд манайхан гадны зөвлөх авахаар ажил нь иймэрхүү хөндий хүйтэн юм гарчихаад, таны хэлээд байгаа тэр ш дээ, энэ мэдээллийн тогтолцоо чинь бүгдээрээ тус тусдаа зөвлөхөөр юмаа хийлгэчихсэн. Жишээ нь: Ашигт малтмалын газар Дэлхийн банкны шугамаар бүх мэдээллийн тогтолцоогоо хийлгэсэн гэх мэт. Энэ дээр миний хувийн бодол бол энэ зүйлийг би хүлээн зөвшөөрөхгүй ажлын хэсэгт. Ийм санал оруулж байна.

**Б.Долгор:** Энэ асуудлыг хэлэлцье гээд нэлээн нарийвчилж тавьсан юм л даа. Тэгээд хүн нь ч байхгүй, иймэрхүү юм тараачихсан байдаг. Одоо нэгэнт энд үндэсний зөвлөх Ч.Энхзаяа байна. Энэ асуудал яригдлаа, ийм боллоо. Бид бол эндээс ямар шийдвэр гаргах вэ гэхлээр үүнийг хэлэлцүүлэх ёстой гэж үзэж байна. Хэлэлцүүлэхдээ маш хариуцлагатай хандах хэрэгтэй, Чулуунбаатар байхаа. Энэ Монгол талын хуулийн ажилтан маань иймэрхүү маягтай ажиллах юм бол болохгүй л байна л даа. Тэгээд хэлэлцүүлье гэхээр байхгүй болчихдог. Тэр нь өөрөө ямар шалтгаантай юм бэ гэдгийг бид мэдэхгүй байна. Ийм маягтай ажилавал бид цаашдаа хүлээж авч чадахгүй. Үнэхээр ажиллая гээд хариуцлагатай юм танилцуулбал бид албан ёсоор хэлэлцэж байж энэ асуудал дээр хариу-өгнө.

**Ч.Энхзаяа:** Энэ Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Адам Смит Интернэйшнл-ийн компаний төслийн талаар мэдээлэл та бүхэнд хүрсэн байх. Миний хувьд бие даасан зөвлөхөөр ажилладаг. Хоёр газар одоогийн байдлаар зөвлөхөөр ажиллаж байгаа. Олборлох үйлдвэрлэлийн засаглалийн асуудлаарх Адам Смитийн төслийн Монгол талын ахлах зөвлөх гэж явж байгаа. Нөгөө нь Дэлхийн банкны олборлох үйлдвэрлэлийн асуудлаарх зөвлөхөөр ажиллаж байна. Тийм учраас Дэлхийн банк, Адам Смит аль аль талаасаа та нартай хамтран ажиллах бололцоо гарч байгаад баяртай байна. 2-т саяны тайлантай холбоотой залруулга ойлголтыг цэгцлэх хэрэг гарч байгаа юм шиг санагдаж байна. Энэхүү тайланг та нар зөвхөн энэ презентацаар хязгаарлаж болохгүй. Энэ тайланг урьдчиладаа англи болон монгол хэл дээр 40 хуудас материал тараасан байгаа. Ажлын албанаас тараасан байх.

**Ш.Цолモン:** Мейл-ээр бүгдэд нь явуулж тараасан.

**Ч.Энхзаяа:** Өнөөдрийн хувьд хурал дээр хэлэлцэхэд нэмэр болох юм уу гэсэн үүднээс та бүхэнд презентац маягаар өгсөн. Үндсэн тайлан 40 хуудас. Батпүрэв

тайлангаа уншаагүй байх шиг байна. Түүний тавьсан бүх асуултад хариулт өгчихсэн байгаа энэ тайлан дээр. Бас энэ тайланг сайн уншиж ажиглаад тэрэн дээр саналаа, одоо заавал өнөөдрөөр хязгаарлах албагүй, хэлээрэй. Саналыг бичгээр болон бусад хэлбэрээр хүлээн авахад бэлэн байна. 2-т тайлангийн энэ удаагийн зорилгыг санаачлагатай тохиролцсон байгаа. Юу гэхлээр өнөөгийн байдал ямар байгаа гэдэгт дүгнэлт дун шинжилгээ хийгээд хувилбарууд санал болгох. Өөрөөр хэлбэл 3-н хувилбар байж болох юм байна гэж үзсэн. Алийг сонгох нь Санаачлагын өөрийнх нь эрх мэдлийн асуудал. Нэг л хувилбар дээр тусдаа нэг хууль байх хэрэгтэй гэсэн. 2-3 дахь бусад хувилбар байгаа та бүхэн судлана биз. Алийг сонгох, мөн тэрнээс өөр хувилбар гаргах нь Санаачлагын өөрийнх нь асуудал. Тэр шийдвэрийг Санаачлага гаргасны үндсэн дээр суурилаад хуулийн ямар дэмжлэг хэрэгтэй байгаа юм вэ, хууль боловсруулахад дэмжлэг хэрэгтэй бол тэрийг үзүүлье. Одоо байгаа хуулин дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй бол тэрэн дээр нь дэмжлэг үзүүлье гэсэн ийм хувилбаруудыг гаргасан байгаа. Тийм учраас та бүхэн тайлангийнхаа зорилгыг тайлан гаргасан хүмүүсийн өмнө ямар даалгавар тавигдсаныг анхаарч үзээд тэрэнтэй нь харьцуулж үзээд саналаа өгөөрэй гэж хүсэх байна. Чулуунбаатар ирж чадаагүйд би ч бас харамсч байна. Анх энэ хурлыг пүрэв гарарт болно гэж хэлсэн учраас манай хүн ирэхэд бэлэн болсон, төлөвлөсөн байсан. Энэ хуралдаан 5 дахь өдөр болохоор хойшлогдсон учраас, мөн өөр бие даасан хуульчаар ажилладаг учраас хуулийнхаа шугамаар шүүх хуралтай холбоотой хөдөө явах хэрэгтэй болсон учраас ирж чадахгүй боллоо гэдгээ Ажлын албанд танилцуулсан байгаа. Энэ шүүмжлэлийг би түүнд хүргэе. Хариуцлагатай ажиллах талаар өөрөө биеэр ирж илтгэл тавих тал дээр би дамжуулъя. Та нарын цагийн боломжийг тохируулж байгаад дахиад хэлэлцэхэд асуудалгүй байхаа гэж бодож байна. Мөн энэ тайланд өөр юуг тусгаж болох вэ гэсэн саналыг авч болж байна, эсхүл өөр ямар нэг 3, 4, 5 дахь хувилбар гаргах юм уу, мөн та нарын санал дээр суурилаад, хэрэв тусад нь хууль гаргая гэвэл ямар үзэл баримтлал гаргах вэ гэдгийг нь гаргая.

**Б.Долгор:** Үүнийг асуудлаа хэлэлцэхдээ ярья.

**Шийдвэрлэсэн нь:** Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох, авах арга хэмжээний тухай төслийн багийн тайланг гишүүд танилцсаны дараа Ажлын хэсгийн дараагийн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Б.Долгор хуралдааныг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 14 цаг 10 минутад хааж, гишүүдэд баярласнаа илэрхийлэв.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
Ажлын хэсгийн ахлагч



Б.ДОЛГОР

Ажлын албаны ажилтан



С.БАТБАЯР